

МОНГОЛ АЛТАЙД ИЛЭРСЭН ПАЛЕОЛИТЫН ҮЕИЙН

АЛГАНЫ УРВУУ ДҮРСЛЭЛ

(Хөх булгийн хөмөг, Говь-Алтай аймаг)

Ц. Төрбат^{1,*}, О. Нэргүй², Ц. Цэлхагарав³

Товч агуулга: Хуучин чулуун зэвсгийн үеийн хадны зургийн дурсгал Говь-Алтай аймгийн Тонхил сумын нутагт Алтайн нурууны урд биед байх Хөх булгийн рашааны хойд их ханан хадны ард хормойд нэгэн жижиг хөмөгт илэрсэн байна. Энд нийт 21 зураг дүрслэлийг улаан ба хар хөх өнгийн зосоор үйлджээ. Хамгийн олон тоотой нь нийт 13 ширхэг алганы урвуу дүрслэлүүд бөгөөд палеолитын зургийн хэв загвар, техникээр бүтээгдсэн байна. Мөн энд байх хүний дүрслэл, геометр дүрслэлүүд нь дэлхий даяар түгээмэл тархсан палеолитын үеийн агуйн зосон зургийн дурсгалуудтай адилсах юм. Энэхүү дурсгал Төв Азийн гүнд анх удаа илэрч байгаа палеолитын үеийн алганы урвуу дүрслэл болохын хувьд онц сонирхолтой болно.

Түлхүүр үг: Хадны зураг, алганы урвуу дүрслэл, палеолитын үе, хадны зураг, зосон зураг, Монгол, Алтай

Удиртгал

Таван жилийн өмнө буюу 2018 онд Монгол улсын Соёлын гавъяат зүтгэлтэн, зохиолч, сэтгүүлч Г.Аким гуай Говь-Алтай аймгийн Тонхил сумын Соёлын төвийн эрхлэгч Батсуурь гуай руу утсаар ярьж танай суманд улаан өнгөтэй гарын алганы зураг байгаа тухай сонссон, тэр талаар тодруулбал надад мэдэгдээрэй гэсэн байжээ. 2020 оны намар Т.Батсуурь гуай хээр зугаалсан сурагч хүүхдүүдийн гэрэл зургийг санамсаргүй үзэж байгаад олон хүүхдүүд тошлойн бутны өмнө нэгэн хөмөгт авахуулсан зургийн ар фононд нөгөөх улаан алганы зургийг олж харж гэнэ. Тэгээд Г.Аким гуайд мэдээлсний дагуу нөгөө хүн удалгүй Тонхил суманд нь ирсэн ажээ. Энэ зуур 10 сар нэгэнт дундаа орж цас хаяж хүйтэрсэн тул уг газарт хүрэх зам бэрх болсон байжээ. Ялангуяа газрын ойр бөгөөд аялагч хүүхдүүдийн анх очсон хойд талаас нь хүрэх боломж үгүй болсон тул газрын намаас буюу говь талаас нь их холоос өгсөж зүтгэхээс өөр аргагүй болжээ. Анх үзсэн хүмүүс замчилж өгсөн тул уг зургаа төвөггүй олсон боловч 5 км гаруй газар цасан дундуур олон цаг өгсөж зүтгэсээр арай гэж хүрсэн түүхтэй юм байна. Уг зургийн талаар Г.Аким гуай тэмдэглэл бичиж нэлээд олон нийтэлсэн тул олон нийт сайн мэддэг болжээ (Аким 2020). Гэхдээ мэргэжлийн археологич очиж үзээгүй хэвээр байсан юм.

Ингээд 2021 оны 6-р сард Ц.Төрбат, Ц.Цэлхагарав, О.Нэргүй нарын удирдсан археологийн малтлага

Тонхил сумын Шадатын бэлчирт хийгдэж байх үеэр Батсуурь гуай биднийг зорин ирж Хөх булгийн хадны зургийг замчлан үзүүлэхээр болсон таатай боломж үүссэн тул бид мэргэжлийн судлаачдын дундаас анх удаа Хөх булгийн хадны зосон зургийг үзэв (Зураг 1-2) (Төрбат нар 2021). Энэ гүймэг судалгааны явцад хадны зургуудын нарийвчилсан гэрэл зургуудыг масштаб хэмжээ тавьж авснаас гадна хөмгийн 3D загварыг хийх гэрэл зургуудыг буулгав.

Энэхүү товч өгүүлэлд бид Хөх булгийн хадны зургийн эх хэрэглэгдэхүүнийг нийтэлж, хөрш бүс нутгийн ижил төстэй дурсгалуудыг танилцуулахын зэрэгцээ дурсгалын он цагийн асуудалд анхаарлаа хандуулав. Энэхүү хадны зургийн судалгаа цаашид үргэлжлэх нь дамжиггүй бөгөөд ялангуяа байгалийн шинжлэлийн аргаар зургийн химийн бүтэц найрлагийг тогтоох ажил хүлээгдэж байна. Хөх булгийн хадны зураг цаашид дэлхийд Монголын нэрийг дуурсгасан дурсгал болно хэмээн итгэлтэй байгаа бөгөөд тодруулж хэлбэл хүн төрөлхтний урлагийн үүслийн асуудлыг хэлэлцэхэд зайлшгүй дурдагддаг нэгэн чухал дурсгал болох юм.

Судалгааны эх хэрэглэгдэхүүн

Говь-Алтай аймгийн Тонхил сумын Алтансоёмбо багийн нутагт орших Хөх булгийн хадны зураг нь хойшоо харсан томхон хөмөгт байрлана (Зураг 1, 3). Энэхүү том хад нь Хөх булгийн рашааны дээхэн талд байрласан учир Т.Батсуурь гуай энэхүү дурсгалыг ингэж нэрлэжээ. Хөмөг байрлаж байгаа аварга том хад нь урдаас харвал зүүн гар тийш налсан боржин блок юм (Зураг 1). Түүний ар талд хойшоо харсан нар

¹ МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, Антропологи, Археологийн тэнхим

* Холбоо барих зохиогч: turbat.ts@num.edu.mn

<https://orcid.org/0000-0001-6606-8516>

² Говь-Алтай аймгийн музей


³ ШИА, Археологийн хүрээлэн

үзэхгүй 6 м өргөнтэй, 2 м гүнтэй, 2-2,5 м өндөртэй хөмөг бий. Энэхүү хөмгийн хананд нийт 21 ш зураг дүрслэл улаан ба хар хөх өнгийн зосоор зурагджээ (Зураг 4). Зарим зургуудыг шүршиж бүтээсэн учир зурагдсан гэдэг нэр томъёог бид болзмол байдлаар хэрэглэсэн болно. Учир нь энд нийт 13 ш алганы урвуу дүрслэл байхыг бүгдийг шүрших аргаар

негатив дүрслэл үүсгэн бүтээжээ. Мөн хүний нэгэн загварчилсан дүрслэлийг улаан зосоор зурсан байна. Эдгээр гарын алганы дүрслэлүүд 3 бүлэг болж байрлажээ. Мөн хүний нэг ширхэг дүрслэл, “зүрх” мэт үл ойлгогдох дүрслэл бас нэг ширхэг богино ташуу зураас, 3 хэсэг чагталсан зураасууд, 2 улаан өнгийн толбыг мөн дурдах нь зүйтэй.




Зураг 1. Хөх булгийн хөмөг, Говь-Алтай аймгийн Тонхил сум (2021 © Ц.Төрбат)



Зураг 2. О.Нэргүй ба Т.Батсуурь нар Хөх булгийн хөмгийн зургийг баримтжуулж байгаа нь (2021 © Ц.Төрбат)



Зураг 3. Хөх булгийн хөмгийн байршил



Зураг 4. Хөх булгийн хөмөг. Бүлэг зургуудын байрлал. “Agisoft Metashape” програмаар хийсэн 3D загвар
(2021 © Ц.Төрбат)



Зураг 5. 1-р бүлэг зураг буюу хар хөх өнгийн урвуу алганы дүрслэл.
А. Өнгөт эх зураг, В. “DStretch” багажаар “YBK” горимоор өнгийг гүнзгийрүүлсэн зураг
(2021 © Ц.Төрбат)

1-р бүлэг зураг. Хөмгийн зүүн төв хэсэгт баруун зүгт хандсан хананд байх 2 хар хөх алганы урвуу дүрслэл болно (Зураг 5). Дээр талын илүү томхон алганы дүрслэл нь дунд хурууны үзүүрээс шууны хэсэг хүртэл 25 см урттай байна. Харин доодох зураг нь арай жижиг хэмжээтэй мэт харагдах боловч үнэндээ бараг адил хэмжээтэй бөгөөд шууны хэсэг дүрслэгдээгүй учир ингэж харагдаж байгаа юм. Аль аль алганы дүрслэл баруун гарынх байгааг тэмдэглэе.

2-р бүлэг зураг. Хөмгийн амны эсрэг талд хойшоо харсан байдалтай том тэгш гадарга дээр төвлөрч байрласан зургууд байна (Зураг 6). Гол хэсгийн том гадарга дээр 5 улаан өнгийн алганы урвуу дүрслэл байна. Түүнээс нэлээд доохон талд нь мөн нэгэн улаан өнгийн алганы урвуу дүрслэл тасархай байрлажээ. Эдгээр 6 урвуу дүрслэлийн 5 нь баруун алганых, харин

хамгийн захад байгаа шууны хэсгийг нь бараг тохойг хүртэл их урт дүрсэлсэн нэг зураг нь зүүн алганых байна. Гол хэсгийн зүүн гар талд бараг адил өндөрт 2 хэсэг үл ойлгогдох улаан зосон толбо байгааг мөн дурдая (Зураг 6-В). Түүнчлэн энэ хоёр дүрслэлийн дээр нэгэн жижиг ташуу зураас бий.



Алганы дүрслэлүүдийн дундуур зураг бүхий талбайн дээр хэсгээр 3 газарт чагталсан зураасууд байгааг илүү улбар өнгийн будгаар зуржээ. Эдгээр зураас дарим талаар алганы дүрслэлүүдийг дарсан мэт харагдаж байгаа тул харьцангуй хожуу үеийнх байж болно. Гэхдээ палеолитын урлагт алганы дүрслэлүүд ба геометр дүрслэлүүд нэг талбайд, нэг цаг үед бүтээгдэж нэг нэгийнхээ утга санааг баяжуулсан байдалтай байдгийг дурдая.



Зураг 6. 2-р бүлэг зураг буюу 6 ширхэг улаан өнгийн алганы урвуу хээний дүрслэл
А. Өнгөт эх зураг (2021 © Ц.Төрбат), В. “DStretch” багажаар “YRE” горимоор өнгийг
гүнзгийрүүлсэн зураг, С. Алганы дүрслэлүүдийн завсарт байгаа чагталсан зураасууд

3-р бүлэг зураг. Хөмгийн баруун хананд зүүн тийш харсан гадарга дээр газраас дээш 30 см орчим өндөрт байрласан 2 ширхэг улаан өнгийн алганы урвуу дүрс (Зураг 7-В), мөн 3 ширхэг хар хөх өнгийн алганы урвуу дүрс нэгэн бүлэг болж байна (Зураг 7-С). “DStretch” хэрэгсэл ашиглан дээрх хоёр өөр өнгийн алганы дүрслэлүүдийг өөр өөр горим дээр тодотгон харах боломжтой болсныг энд дурдая. Арай дээр байгаа алганы дүрслэл нь баруун гарынх, харин түүний доор байгаа нь баттай биш боловч зүүн гарынх бололтой байна. Учир нь хоёрдугаар алганы дүрсний нэг хуруу нь тодорхой хадгалагдаагүй ажээ.

Дүрслэлүүдийг зөвхөн алганы хэсэг ба хуруунууд төдийгүй шууны хэсгийг ч оруулан шүршиж бүтээжээ. Хар хөх өнгийн алганы урвуу дүрслэлүүд бүгдээрээ баруун гарынх байна. Эдгээрийг хадны тохиромжтой гадаргийн захаар үйлдсэн нь дарааллын хувьд улаан алгануудаас арай хожуу болов уу гэсэн сэтгэгдэл төрүүлж байхын хажуугаар яагаад зөвхөн зарим гадарга дээр дүрслэлүүдийг нягт хийгээд зарим тохиромжтой гадарга дээр огт дүрслэл үгүй байгаа тухай хадны зургийн судалгаанд байнга тавигддаг хариулт үгүй асуултыг дахин нэг удаа тавихад хүргэж байна.



Зураг 7. 3-р бүлэг зураг буюу улаан өнгийн хоёр алганы урвуу хээний дүрслэл
А. Өнгөт эх зураг (2021 © Ц.Төрбат), В. “DStretch” багажаар “CRGB” горимоор өнгийг гүнзгийрүүлсэн зураг,
С. “DStretch” багажаар “YBK” горимоор өнгийг гүнзгийрүүлсэн зураг


Хүний дүрслэл. Хөмгийн хойшоо харсан өргөн талын доод хэсэгт 2-р бүлэг зургийн зүүн доод хэсэгт нэгэн хүний дүрслэл байна (Зураг 8-B, D). Уг дүрслэлийг улаан өнгийн зосоор зураас татан зуржээ. Босоогоороо 25 см урттай, 1,3-1,8 см өргөнтэй зураасаар зурсан. Хэдийгээр толгойг нь мэдэгдэхүйцээр дүрслээгүй боловч хос гар ба хөл, эгц босоо их бие, мөн магадгүй эр бэлэг эрхтэн зэргээс харахад хүнийг дүрсэлсэн нь илэрхий мэдэгдэж байна. Гар ба хөлийг тус бүр 3 хуруутай мэтээр нэлээд хэтрүүлэгтэй том дүрсэлсэн байна.

Уг дүрслэл алганы урвуу дүрснүүдээс бага зэрэг зайтай ганцаараа байх боловч бид хэрэглэсэн будаг, ба дүрслэл зүйн онцлог зэргээрээ бусад зургуудтай нэгэн цаг үед холбогдоно хэмээн үзэж байна. Мөн хүний дүрслэлээс доохон талд нь нэгэн үйл ойлгогдох дүрслэл байгаа нь хялбарчилж харвал “зүрх” мэт дүрсийг үүсгэнэ (Зураг 8-D).

Палеолитын үеийн агуйн зургуудад хүний дүрслэл харьцангуй ховор байдаг. Нэлээд алдартай зургийн дотор Ляско агуйн “шархадсан хүн” нэртэй өгүүлэмж багтдаг билээ (Зураг 8-C). Энд нэгэн бухны

өмнө мөргүүлж шархадсан бололтой хүнийг бодит байдлаар дүрсэлжээ. Палеолитын үеийн агуйн зурагт дүрслэгдсэн хүмүүсийн дүрслэл нь ихэвчлэн ямар нэг амьтны баг өмссөн юм уу эсвэл бүр арьс нөмөрч амьтны дүрд хувирсан байдалтай байдаг ажээ.

Хөх булгийн хөмгийн хадны зурагт байгаа энэхүү хүний дүрс (Зураг 8-B) нь Өмнөд Америкийн Куэва де лас Манос агуйд байдаг хүний дүрслэлтэй (Зураг 8-A) цочирдмоор төстэй байгааг тэмдэглэхгүй өнгөрч боломгүй юм. Өмнөд Америкийн ба Монгол Алтайн зурагт буй хүнийхээ их биеийг болон мөчдийг нь дан зураасаар дүрсэлсэн, хөл ба гарыг 90° огцом нугалсан, хуруунуудыг онцгойлон цохон дүрсэлсэн зэрэг дүрслэлзүйн ижил төстэй байдал илт ажиглагдах юм. Хэдийгээр Ляскогийн хүнийг арай өөрөөр, тухайлбал их биеийг нь овор хэмжээ өгч зэрэгцээ зураасаар дүрсэлсэн боловч хөл гарыг мөн л дан зураасаар дүрсэлсэн байдалтайг дашрамд нь дурдая. Ер нь энэ хүнийг Ляскогийн уран нарийн, олон өнгө хослуулан бүтээсэн бусад амьтдын зургаас илт өөрөөр маш энгийнээр дүрсэлсэн байгаа нь сонирхолтой.



Зураг 8. Хүний дүрслэл. А. Өмнөд Америкийн Аргентиний Куэва де лас Манос агуй, В. Монгол Алтайн Хөх булгийн хөмөг (2021 © Ц.Төрбат), С. Францын Ляско агуйн “шархадсан хүн” өгүүлэмж, D. Хүний дүрслэл ба үл ойлгогдох дүрслэл. “DStretch” багажаар “CRGB” горимоор өнгийг гүнзгийрүүлсэн зураг (2021 © Ц.Төрбат)

Хэлэлцүүлэг

Алганы урвуу дүрслэл дэлхий даяар түгээмэл тархжээ. Хамгийн ойрын ижилсэх дурсгал бол Дундговь аймгийн Адаацаг сумын нутаг Гэр чулууны дурсгал юм. Энэхүү дурсгалыг А.П.Окладников анх 1981 онд нийтэлсэн бөгөөд дараа дараагийн бүтээлүүдэд олонтоо эшлэгдэн хэвлэгдсэн (Окладников 1981: 17-18, Табл. 47-1). Харин сүүлийн үед энэ дурсгалыг дахин үзэж, ялангуяа гэрэл зураг авсан судлаач миний мэдэхээр үгүй байна. Гэхдээ Зөвлөлтийн нэрт археологийн нийтлүүлсэн зүйлд эргэлзэх шаардлага үгүй бөгөөд ямар боловч хоёр алганы урвуу дүрслэл байсан юм уу байгаа бололтой.

Дараагийн ойрхон дурсгал бол БНХАУ-ын Өвөр Монголын Алшаа баруун хошууны Яврай уулын агуйн зургууд юм. Энэ ууланд алганы урвуу дүрслэл бүхий Элсэн хөтөл, Тооройн гол зэрэг хэд хэдэн агуй байдаг нь Хятадад байгаа ийм хэлбэрийн дүрслэлийн хамгийн том бөөгнөрөл ажээ (Hernanz et al. 2016). Бадайн Жаран элсэн цөлийн зүүн урд хэсэгт байх Яврайн нуруу шулуун шугамаар Хөх булгийн хөмгөөс зүүн урагшаа 1000 км зайд оршдог.

Мөн Шинжааны Алтайн Дугарт (Duogart, Duogarte, Dugat) хадны хөмөгт ийм зосоор шүршсэн алганы дүрслэлүүд байдаг (Taçon et al. 2016). Уг дурсгал Казахстаны хилээс 10 км зайд Хаба хошууны нутагт байдаг. Хөх булгийн хөмгөөс баруун хойшоо шулуун шугамаар 610 км орчимд байна. Энд нийт хадны зураг

бүхий 7 хөмгөөс бүрддэг дурсгалт газар ажээ (Зураг 9). Уг дурсгалын зургуудыг нийт 5 үе шатанд бүтээсэн бөгөөд хамгийн эртнийх нь алганы урвуу дүрслэлүүд ажээ. Харин эдгээр алганы дүрслэлийн он цагийг Австрали-Хятадын хамтарсан төслийн судлаачид нарийн тодорхойлоогүй боловч тус дурсгалын арай хожуу үеийн зургуудыг цаг уурын баримтыг үндэслэн 5250-4000 жилийн өмнө гэж үзсэн байна. Гэхдээ алганы урвуу дүрслэлүүд нь зураг бүхий талбайн хамгийн доод ирмэгийн дагуу ашигтай хэсгийг эзэлсэн бөгөөд илэрхий хожуу үед, магадгүй неолитоос-хүрлийн эхэн үед холбогдох зосон зургууд нь эдгээр алганы дүрслэлүүдийг дарж дээр нь зурагдсан байгаа тул хавьгүй эрт цаг үед хамаарч болохыг тэмдэглэе.

Эдгээрээс гадна Хятадын Нинся, Хөх нуур, Юннань, Гуйжоу зэрэг мужуудын нутагт ч алганы урвуу дүрслэлүүд илэрчээ. Тухайлбал, Шинжааны Фуюн хошууны Улкенкус (Зураг 10), Хөх нуур мужийн Ганча хошууны зургууд (Зураг 11) нэлээд төлөөлөх шинжтэй болох тул дурдах нь зүйтэй. Эдгээр нь мөн л алганы урвуу дүрслэлүүд бөгөөд боржин чулуун хөмөгт нэг дор олноор нь дүрсэлсэн зураг шинжээрээ манай Хөх булгийн зургуудтай адилсаж байна. Хөхнуурын Ганчагийн зураг шулуун шугамаар Хөх булгийн зургаас зүүн урагшаа 1000 км зайд оршино. Харин Шинжааны Улкенкусын зураг шулуун шугамаар баруун зүгт ердөө 330 км зайд оршиж байгаа юм.

Төв Азийн бүс нутагт Узбекистанаас өөр улсад



Зураг 9. Шинжааны Алтайн Дугартын алганы урвуу дүрслэл бүхий хөмөг (Taçon et al. 2016: Fig. 11)

алганы урвуу дүрслэл илрээгүй байна. Узбекистаны Каратау уулын өмнөд бэлд байх Аксакалата-Сай дурсгалт газар алдарт Сармишсай хадны зургийн дурсгалаас ердөө 12 км зайтай оршдог (Khujanazarov 2011: 105). Хэрэв Сармишсай илүү түрүү хүрлийн үеийн зургуудтай бол Аксакалата-Сайд янз бүрийн үеийн зургуудтайн дотор илүү эртний зургууд ч байгаа бололтой.

Баруун Европын агуйн хадны зургийн хамгийн том бүс нутаг болох Франк-Кантабрын мужид 20 гаруй агуйд ийм төрлийн дүрслэл байдаг нь дэлхий дээрх хамгийн том бөөгнөрөл болно. Үүний дараа Индонезийн Сулавеси арал дахь бүлэг агуйд мөн

алганы урвуу дүрслэлүүд бий. Алганы дүрслэлийн харьцангуй тусгаарлагдмал цэгүүд ч дэлхий дээр бий. Тухайлбал, Аргентиний Куэва де лас Манос агуй ихээхэн алдартай бөгөөд ЮНЕСКО-ийн Дэлхийн өвийн жагсаалтад багтсан байдаг. Бид алганы урвуу дүрслэлийн он цагийг авч хэлэлцэхдээ дээрх гурван бүс нутгийн хэмжээнд хязгаарлаж үзэв.

Марос-Пангкепийн карстын агуйнууд Индонезийн Сулавеси арлын өмнөд хэсэгт оршдог бүлэг агуй юм. Марос-Пангкепийн агуйнуудын гарын алганы зургууд (Зураг 12) одоогоос 35,000-40,000 жилийн өмнө холбогдох бөгөөд дан ганц зүүн гарынх төдийгүй баруун гарын зураг байдгаараа онцлогтой



Зураг 10. БНХАУ-ын Шинжааны Улкенкусын хадны зураг (Region 2011: 80)




Зураг 11. БНХАУ-ын Хөхнуур мужийн Ганчагийн хадны зураг (интернет дата)



Зураг 12. Марос-Пангкепийн бүлгийн агуйн доторхи гарын алганы зургууд (https://commons.wikimedia.org/wiki/File:Hands_in_Pettakere_Cave.jpg#/media/File:Hands_in_Pettakere_Cave.jpg)

юм. 2014 оны судалгаагаар дээрх зургууд 39,900 жилийн тэртээх үед холбогдохыг тогтоожээ (Aubert et al. 2014). Ингэснээрээ уг зураг одоогоор дэлхийд мэдэгдэж байгаа хамгийн эртний гарын алганы зураг болж байгаа юм.

Харин Евразийн эх газрын баруун хязгаарт агуйн зургийн хамгийн том голомт болох Франк-Кантабрын бүс нутагт байгаа хамгийн эртний гарын алганы зураг нь Эль Кастильо агуйд байгаа бөгөөд үнэмлэхүй он цаг нь наад зах нь 37,290 жилийн тэртээд хэмээн тогтоогдсон байдаг (García-Díez et al. 2015). Гэхдээ энэ агуйд буй улаан өнгийн дугуй дүрсний он цаг 40,800 жил байгаа бөгөөд судлаачдын үзсэнээр бол бүтээсэн техник ба өнгө нь адил байгаагаас харахад Эль Кастильо агуйн зургуудын он цаг Индонезийн



Зураг 13. Эль Кастильо агуй *G* хумханд байгаа гарын алганы хээ ба үнэмлэхүй он цагийн дээж авсан цэгүүд (García-Díez et al. 2015: Fig. 3)

зургуудынхтай бараг нэг адил бололтой. Энэ хоёр дурсгалын аль алины үнэмлэхүй он цагийг тогтоохдоо зургуудыг бүрхсэн кальцитийн он цагийг У-серийн аргаар тогтоох аргыг хэрэглэсэн байдаг (Зураг 13).

Газар дундын тэнгисийн эрэгт байх Коскэ (Cosquer) агуйн урвуу дүрслэлүүдийг одоогоос 27,000 жилийн тэртээд бүтээсэн нь үнэмлэхүй он цагийн ^{14}C аргаар тогтоогджээ (Morley 2007: 74). Энэхүү дурсгал бол палеолитын урлагийн хамгийн том бөгөөд сайн хадгалагдсан голомтуудын нэг билээ. Гэхдээ хамгийн чухал нь Коскэ агуйн ам нь сүүлийн арван мянган жилийн турш тэнгисийн усан доор байсан тул хүний үйл ажиллагааны улмаас дүр байдал нь гэмтээгээгүй, иймээс ч он цагийг нь үнэмлэхүй аргаар тогтоох маш найдвартай сурвалж болдог юм.



Зураг 14. Куэва дө лас Манос агуйн гарын алганы зургууд (<https://commons.wikimedia.org/wiki/File:SantaCruz-Cueva-Manos-P2210651b.jpg#/media/File:SantaCruz-CuevaManos-P2210651b.jpg>)

Гарын алганы зураг Евразийн эх газар төдийгүй Америк тивд хүртэл тархсан байдаг нь энэхүү үзэгдэл үнэхээр дэлхийн хэмжээний төдийгүй он цагийн хувьд ч дан ганц палеолитын үе төдийгүй илүү өргөн хүрээтэй болохыг харуулдаг. Нийтийн мэдэж байгаагчлан Америк тивд хүн нэвтрэн орж суурьшсан он цаг 15,000-20,000 жилийн тэртээд холбогддог билээ. Чулуун зэвсгийн үеийн соёлын хэв маягийг агуулсан Америк тивийн уугуул оршин суугчид харьцангуй богино хугацаанд энэхүү тивийг эзэмшиж хуучин тивээс авчихсан хадны зургийн соёлоо дэлгэрүүлсэн ажээ.

Америк тивд байгаа гарын алганы зургуудын дотроос хамгийн алдартай нь Аргентин улсын өмнөд хэсгийн Санта Круз мужийн нутагт байх Куэва дө лас Манос агуйн зургууд юм (Onetto 2014) (Зураг 14). Эдгээр зургийг 9,500 орчим жилийн өмнө бүтээсэн

болохыг үнэмлэхүй болон стратиграфийн аргаар тогтоожээ. Ингэхдээ юуны өмнө будгийг шүрших ясан хонгионуудын ^{14}C он цагийг тогтоох, зургуудын ^{14}C он цагийг шууд дээж авч тогтоох зэрэг үнэмлэхүй аргуудыг хэрэглэсэн байна. Уг агуйн зургуудыг бүтээхдээ хар ба улаан өнгийг зэрэгцүүлсэн байгаа нь Хөх булгийн хөмгийн зургуудтай адилсаж байна. Мөн хүний загварчилсан дүрсийг зурахдаа гар хөлийг нь огцом нугалж, хуруунуудыг нь тодотгон дүрсэлсэн арга барил нь Хөх булгийн хөмгийн хүний дүрстэй нэн адилхан.

Дээрх цөөн жишээнээс үзэхэд дэлхийн хэмжээнд өргөн тархацтай алганы урвуу дүрслэлийн он цаг 40,000 орчим жилийн тэртээгээс 9000 орчим жилийн хооронд холбогдож байна. Хэдийгээр 9000 жил гэсэн сүүлчийн он цаг нь сонгодог археологийн үечлэлээр палеолитын үеэс хожуу мэт харагдаж байгаа боловч уг

дурсгал байрлаж байгаа Өмнөд Америкийн хамгийн урд хэсгийн хувьд палеолитын үе үргэлжилсээр байсныг дурдах нь зүйтэй. Иймээс алганы урвуу дүрслэлийн он цагийг бүхэлд нь палеолит буюу хуучин чулуун зэвсгийн үед хамааруулж болно.

Палеолитын үеийн хадны зурагт хүний алганы дүрслэл нь: шууд дардас (позитив дүрслэл) ба урвуу дүрслэл (негатив дүрслэл) гэсэн хоёр үндсэн төрөл байдаг. Гэхдээ шууд дардас нь урвуу дүрслэлээс харьцангуй цөөн тоотой бөгөөд ихэвчлэн Францын Роне мөрний хөндийд төвлөрсөн байдалтай тархсан байдгийг тэмдэглэх нь зүйтэй (Morley 2007: 72). Алганы дүрслэлийн аль ч хэлбэр нь бодит хүний шууд ул мөр болдог бөгөөд индивидуал шинжтэй тул палеолитын үеийн дүрслэх урлаг дотор онцгой байр суурьтай байдаг.

2003 онд хийгдсэн судалгаагаар агуйн хадны зургийн Франк-Кантабрын мужид нийт 22 дурсгалт газарт хэдэн зуун алганы урвуу дүрслэл бүртгэгджээ (Morley 2007: 73). Ийм урвуу дүрслэлийг бүтээхдээ юуны өмнө гарын алгаа хадны гадарга дээр тавиад нэг бол том багсаар эргэн тойронд нь будаж, эсвэл хонгио ашиглан будгийг амаараа тургиж буддаг байжээ. Эхний аргаар бүтээхэд будгийн түрхэлт жигд бөгөөд хязгаар нь тодорхой гардаг бол хоёрдахь аргаар бүтээхэд будгийн зах хүрээ нь илүү зөөлөн бөгөөд жигд бус байдалтай түрхэгддэг. Гэхдээ багсдаж будах нь харьцангуй ховор харин шүршиж будах нь илүү түгээмэл байжээ.

Алганы урвуу дүрслэлүүдийн сонгодог бөгөөд хамгийн олон тоотой жишээг агуулсан Францын Коскэ (Cosquer) агуйд нийтдээ 43 урвуу дүрслэл байгаагаас 34 нь хар, харин 12 нь улаан зосоор бүтээгдсэн байна. Харин Францын Гаргас агуйд байгаа 154 алганы дүрслэлийн 132 нь зүүн алганы харин үлдсэн 22 нь баруун алганых байжээ (Дэвлет 2004: 142). Үүнээс үзэхэд нэг дурсгалын хүрээнд хоёр өөр өнгийг зэрэгцүүлэн хэрэглэх нь энгийн зүйл бололтой. Хөх булгийн хөмөгт мөн адил хар ба улаан зосийг ашиглан алганы урвуу дүрслэлүүдийг бүтээжээ.

Куэва де лас Манос агуйд дүрслэгдсэн алганы урвуу дүрслэлүүдийн хэмжээ нь 13 орчим настай хүүхдийн гарын алгатай адилтгах хэмжээтэй байгааг судлаачид тэмдэглэжээ. Гэтэл Гаргасын алганы дүрслэлүүд бол бүх нас хүйсийн хүмүүсийн алганы дардас мөр болохыг харуулсан өөр судалгаа ч бий (Дэвлет 2004: 148). Гэхдээ өсвөр насны хүүхдүүдийн алганы дүрслэл байж болох тухай таамаг «инициац» буюу «насанд хүрсний ёслол»-ын үед гүйцэтгэсэн нэгэн зан үйлийн ул мөр байж болох юм. Өмнөд Африкийн Хохое агуй, Францын Пиринейн уулын Гаргас агуй зэрэг олон арван агуйд буй алганы урвуу дүрслэлүүдэд гарын хуруу дутуу байдаг билээ. Үүнийг мөн л палеолитын үеийн «насанд хүрсний ёслол»-

ын үед хуруугаа тасддаг байсан зан үйлтэй холбон тайлбарладаг (Morley 2007: 77-78). Хөх булгийн хөмөгт харин ийм тасдсан хуруутай алганы дүрслэл байхгүйг тэмдэглэе.

Индонезийн Калимантан арлын 30 гаруй агуйгаас 1500 орчим ийм алганы урвуу дүрслэл илэрсэн байдаг. Тэдгээрийн зэрэгцээ цэгүүд, налуу зураасууд зэрэг элдэв дүрсүүд байдаг нь магадгүй алгануудын дүрслэлүүдийг холбосон анагаах увидастай эрч хүчийг дүрсэлсэн байж болох юм. Хөх булгийн 2-р бүлэг зургийн олон зураас, хэрээсүүдийг тайлбарлах өөр бодитой таамаг үгүй байна.

Дүгнэлт

Палеолитын хадны зураг судлалд тавигдаад байгаа нэг гол асуулт бол “янз бүрийн соёлууд “хэрхэн” болон “ямар учраас” маш урт удаан хугацаанд хамаарах асар өргөн газар нутагт илэрхий залгамжлал бүхий зан байдлыг тээж ирсэн бэ” гэдэг асуулт юм (Morley 2007: 70). Өөрөөр хэлбэл, ягаад нэг нэгээсээ алс хол газар нутгуудад харилцан хамааралгүй мэт соёлууд бараг ижил төстэй урлагийн дурсгалуудыг бүтээсэн бэ? гэдэг асуулт хариултаа хүлээсээр байна. Энэ асуултын хүрээнд Монголын зарим дурсгалуудыг ч хамааруулах хэрэгтэй мэт. Тухайлбал, Монгол Алтайн нурууны Хойд Цэнхэрийн агуйн улаан зосон зургууд болон Хөх булгийн хөмгийн зургууд ч алс холын Баруун Европ, Зүүн Өмнөд Ази, эсвэл бүр Өмнөд Америкийн зарим зургуудтай цочирдмоор ижил төстэй байна.

Монгол Алтайн урд бэлээс илэрсэн Хөх булгийн хадны зургийн дурсгал бүхий хөмөгт улаан ба хар хөх өнгийн минерал будгаар шүрших ба будах аргаар бүтээгдсэн нэн эрт үеийн зураг дүрслэлүүд байгаа нь судлаачдын анхаарлыг зүй ёсоор татах учиртай. Ийм зургууд дэлхийн бүх тивүүдэд тархсан байдаг боловч адилхан учир зүйн агуулгатай бөгөөд, хамт илэрдэг бусад төрлийн зураг дүрслэлүүд нь ч гайхалтай төстэй байдаг нь чулуун зэвсгийн үеийн хүмүүсийн нийтлэг сэтгэлгээ ба ертөнцийг үзэх үзэл төсөөлөлтэй холбоотой болов уу.

Хөх булгийн хөмгийн алганы урвуу дүрслэлүүд ба холбоо бүхий бусад дүрслэлүүд, үүний дотор юуны өмнө хүний загварчилсан дүрслэл нь чулуун зэвсгийн үед, магадгүй палеолитын үед бүтээгдсэн байх боломжтой нь харьцуулсан судалгаагаар харагдаж байна. Монгол Алтайн нуруунд дээд палеолитын үед хамруулдаг Хойд Цэнхэрийн агуйн зосон зургууд байдаг нь Хөх булгийн хөмгийн он цагийг ийм эрт цаг үед авч үзэхэд дам боловч дэмжлэг болох юм. Бидний үзэж байгаагаар Хөх булгийн хөмгийн зургууд нь дүрслэлүүдийн бүтэц, хийсэн арга техник болон орон зайн байрлал зэрэг олон шинжээрээ дэлхий даяар түгээмэл тархсан палеолитын үеийн алганы урвуу

дүрслэлүүдтэй ижилсэж байна.

Хөх булгийн зургаас баруун, зүүн, урд зүгт нь 300-1000 км зайд адилтгах алганы урвуу дүрслэлүүд Дундговь аймгийн нутагт болон БНХАУ-ын Өвөр Монгол, Шинжаан, Хөхнуур мужуудад илэрсэн байгаа нь уг дурсгал тасархай ганц үзэгдэл биш харин Төв Азийн эртний алганы дүрслэлзүйн муж байжээ хэмээн үзэх үндэслэлтэй болохыг харуулж байна.

Abstract

PALEOLITHIC HAND STENCILS FROM MONGOLIAN ALTAI (KHÖKH BULAG ROCK SHELTER, GOBI-ALTAI PROVINCE)

by Tsagaan Turbat, Ochirkhuyag Nergui and
Tsogtbayar Tselkhagarav

The discovery of Paleolithic ochre paintings in the vicinity Khokh Bulag rock shelter of the Tonkhil Soum in Gobi-Altai Aimag, nestled on the southern slopes of the Altai Mountains, reveals a diverse array of figurative, animal and geometric depictions. A total of 21 figures, including 13 hand stencils are meticulously created utilizing red and black ochre pigments. Predominantly featured at this site are hand stencils, executed in an archaic style, typically fashioned using Paleolithic techniques. Additionally, the presence of human and geometric motifs within this shelter draws noteworthy parallels with Paleolithic rock art findings across the globe. This discovery stands as a momentous revelation, marking the inaugural appearance of Paleolithic-style hand stencils within Central Asian rock art, thus underscoring its considerable historical and cultural importance.

Keywords: Rock art, hand stencils, paleolithic, ochre paintings, Mongolia, Altai

Ном зүй

Aubert, M., Brumm, A., Ramli, M., Sutikna, T., Saptomo, E.W., Hakim, B., Morwood, M.J., Van Den Bergh, G.D., Kinsley, L., Dosseto, A. (2014) Pleistocene cave art from Sulawesi, Indonesia. – In: *Nature*, Vol. 514(7521): 223–227. DOI: 10.1038/nature13422

García-Diez, M., Garrido, D., Hoffmann, D.L., Pettitt, P.B., Pike, A.W.G., Zilhão, J. (2015) The chronology of hand stencils in European Palaeolithic rock art: Implications of new u-series results from el Castillo cave (Cantabria, Spain). – In: *Journal of Anthropological Sciences*, Vol. 93: 135–152. DOI: 10.4436/jass.93004

Hernanz, A., Chang, J., Iriarte, M., Gavira-Vallejo, J.M., de Balbín-Behrmann, R., Bueno-Ramírez, P.,

Maroto-Valiente, A. (2016) Raman microscopy of hand stencils rock art from the Yabrai Mountain, Inner Mongolia Autonomous Region, China. – In: *Applied Physics A: Materials Science and Processing*, Vol. 122(7): 1–8. DOI: 10.1007/s00339-016-0228-z

Khujanazarov, M. (2011) Rock Art Sites in Uzbekistan. in: J.Clottes (Ed.) *Rock Art in Central Asia. A Thematic Study*. – Paris: ICOMOS, 2011: 99-112.

Morley, I. (2007) New Questions of Old Hands : Outlines of Human Representation in the Palaeolithic. in: C.Renfrew, I.Morley (Eds.) *Image and Imagination: A Global Prehistory of Human Representation*. – Cambridge: McDonald Institute for Archaeological Research, 2007: 69-81.

Onetto, M. (2014) Cueva de las Manos, Rio Pinturas Cave Art. in: Smith, C. (Eds.) *Encyclopedia of Global Archaeology*. – Springer, 2014: 1841-1846.

Region, C.R.B. of the X.U.A. (2011) Integration of the Results of the Third National Cultural Relics Census of the Xinjiang Uyghur Autonomous Region - Xinjiang Rock Paintings. – Beijing: Science Press, 2011.

Taçon, P.S.C., Tang, H., Aubert, M. (2016) Naturalistic animals and hand stencils in the rock art of Xinjiang Uyghur Autonomous Region, north-west China. – In: *Rock Art Research*, Vol. 33(1): 19–31.

Аким, Г. (2020), November 11 Улаан алганы хойноос Уулын Алтайг давсан минь. – In: Өнөөдөр.

Дэвлет, Е.Г. (2004) Альтамира: у истоков искусства. – М.: Алатейя, 2004. – 280 стр.

Окладников, А.П. (1981) Петроглифы Монголии. – Л., 1981. – 228 стр.

Төрбат, Ц., Цэлхагарав, Ц., Батсүх, Д., Нэргүй, О., Бемманн, Я. (2021) Шадатын бэлчирт хийсэн малтлага судалгаа. in: Монголын археологи-2021. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Монголын археологчдын холбоо, ШУА-ийн Археологийн хүрээлэн, МУИС-ийн Археологийн судалгааны төв, Антропологи, археологийн тэнхим. – УБ., 2021: 194-197.

